



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар **A1505**

Алтай хот

“Алтайн залуус-2022” Цогт сумын  
малчин залуучуудын чуулган, арга  
хэмжээ зохион байгуулахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2, 10.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дэх заалт, Удирдлагын зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Залуучуудын гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, цус ойртолт ба угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, үнэт зүйл, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, нийгэм дэх тэдний оролцоог дэмжих зорилгоор “Алтайн залуус-2022” Цогт сумын малчин залуучуудын чуулган, арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 12,13,14-ний өдрүүдэд зохион байгуулж, шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 11,065,000 (арван нэгэн сая жаран таван мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.


3.Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20 <sup>22</sup> оны 08  
дугаар сарын 11 -ны өдрийн 19/505 дугаар  
захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Цайны завсарлага, өглөөний цай-2 удаа Үдийн хоол-2 удаа Оройн хоол-2 удаа	70	68,000	4,760,000
2.	Цогт-Алтай хот-Дөргөн нуур- Алтай хот-Цогт ирж очих автомашинны шатахууны зардал (2 талдаа нийт 974 км)	7 автомашин	615,000	4,305,000
3.	Жуулчны баазын төлбөр	10 гэр*2 өдөр	100,000	2,000,000
Нийт зардал				11,065,000

\_\_оОо\_\_